

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 9/80

Номгон

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер  
төслийн Ингэний сүүний үйлдвэрийн барилгын  
нэмэлт ажлын гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2021-2025 онд Баянхонгор аймагт хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер төслийн ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажлын төсөвт өртөг, магадлалын нэгдсэн дүгнэлтийг үндэслэн зөрүү 1,005,605,885 (нэг тэрбум таван сая зургаан зуун таван мянга найман зуун наян таван) төгрөгийн нэмэлт ажил дээр гүйцэтгэгч компани “Базардарь” ХХК-тай гэрээ байгуулсугай.


2. Гэрээнд заасан хугацаанд тус барилгыг зураг төсвийн дагуу чанартай хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулахыг “Базардарь” ХХК-д үүрэг болгосугай.

3. Нэмэлт ажлыг хурдан шуурхай зохион байгуулж, хийж гүйцэтгүүлэн хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

4. Нэмэлт ажлын төсвийг санхүүжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН

625010101